2026 оны 5-р сарын 27

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХАХУУЛЬ АВСАН ХЭРГҮҮДИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЛЭЭ



Энэхүү мэдээлэл нь иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн талаарх ойлголт, хэргийн шийдвэрлэлтийг ойлгомжтой байдлаар мэдээлэх зорилготой.

Прокурорын байгууллагаас 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан 263 хүнд холбогдох 114 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн байна.

Нийслэл болон Төв, Архангай аймгийн прокурорын газраас өнгөрсөн 7 хоногт буюу 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд хахууль авах, хахууль өгөх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэмт хэрэгт буруутгагдсан 18 хүнд холбогдох 4 хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлүүлж, шүүхээс 17 хүнийг авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хуульд заасан эрүүгийн хариуцлага оногдуулсан байна.

Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийг тоймлон хүргэж байна.

Нийслэлийн прокурорын газраас:

-Б.Б нь нийтийн албан тушаалтан буюу … дүүргийн Татварын хэлтсийн Татварын хяналт, шалгалтын тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа, Н.Х-тай бүлэглэн, “С…” ХХК, “Ш…” ХХК, “Б…” ХХК-д татварын хяналт шалгалт хийх явцдаа албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд бусдаас нийт 70,6 сая төгрөгийн хахууль авсан,

-Х.Т нь нийтийн албан тушаалтан буюу “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” улсын үйлдвэрийн газрын Систем төлөвлөлтийн албанд мэргэжилтнээр ажиллаж байхдаа Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын улсын байцаагч Н.Ж-ийн гуйлтаар татварын цахим системээс мэдээлэл устгасны хариуд бусдаас нийт 117,9 сая төгрөгийн хахууль авсан;

-Н.Х, Ш.Л, Н.Ж нар нь бүлэглэн, “…татварын цахим системээс мэдээлэл устгуулж” давуу байдал олж авах зорилгоор “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” улсын үйлдвэрийн газрын Систем төлөвлөлтийн албаны мэргэжилтэн Х.Т-д нийт 117,9 сая төгрөгийн хахууль өгсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (Нийтийн албан тушаалтан хахууль авах), мөн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хахууль өгөх)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Б.Б-г “нийтийн албан тушаалтан хахууль авах”, “нийтийн албан тушаалтан хахууль өгөх” гэсэн хоёр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ялыг нэмж нэгтгэн нийтийн албанд томилогдох эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 50 сая төгрөгөөр торгох ял,
>
> -Н.Х-г “нийтийн албан тушаалтан хахууль авах”, “нийтийн албан тушаалтан хахууль өгөх” гэсэн хоёр гэмт хэрэгт үйлдсэн гэм буруутайд тооцож, ялыг нэмж нэгтгэн нийтийн албанд томилогдох эрхийг 7 жилийн хугацаагаар хасаж, 4 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, нээлттэй хорих байгууллагад эдлүүлэх;
>
> -Х.Т-г “нийтийн албан тушаалтан хахууль авах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд томилогдох эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, нээлттэй хорих байгууллагад эдлүүлэх, Н.Х-с 60,6 сая төгрөг, Х.Т-с 117,9 сая төгрөг, тус тус гаргуулж улсын орлого болгох, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон бусад нэр бүхий хүмүүст торгох ял оногдуулж шийдвэрлэсэн.

- Ж.Г нь нийтийн албан тушаалтан буюу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны хэлтсийн орлогч даргаар ажиллаж байхдаа Н.Г-тай бүлэглэн холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж,“Б… ” ХХК-ийг тендерт шалгаруулах ашиг сонирхлын үүднээс тус компанийн захирал БНХАУ-ын иргэн ZH-аас 2018-2019 онд нийт 205 сая төгрөгийг бэлнээр, мөн бусдын дансаар дамжуулан 2016- 2019 онд нийт 3 удаагийн үйлдлээр нийт 96,471,100 төгрөгийг шилжүүлэн авч, нийт 301,4 сая төгрөгийн хахууль авсан;

-Мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас газраас 2019 оны 9 дүгээр арын 20-ны өдөр зарласан “Алхан бутлуур нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” нээлттэй тендерийн сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны даргаар ажиллахдаа үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Г-той бүлэглэн холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, нээлттэй тендерт “И...” ХХК-ийг шалгаруулж, давуу байдал бий болгосны улмаас тус үйлдвэрт 257,6 сая төгрөгийн хохирол учруулсан;

-Мөн Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн М.Ж-тай бүлэглэн, холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1 литр хөргөх шингэний нэмэлт бүтээгдэхүүний үнийг 90,750 төгрөг болгон нэмэгдүүлж, тендер зарлаж, хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн “Э...” ХХК-ийг шалгаруулж, давуу байдал бий болгосон,

-“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Худалдан авах ажиллагааны хэлтсийн орлогч даргаар ажиллах хугацаандаа 2021 онд хөрөнгө орлого нь их хэмжээгээр буюу 500 мянган ам.долларoор нэмэгдсэнийг хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах), мөн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг (нийтийн албан тушаалтан хахууль авах), мөн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (хууль бусаар хөрөнгөжсөн)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Ж.Г-г албан тушаалтан албаны эрх мэдлээ урвуулан ашигласан, нийтийн албан тушаалтан хахууль авсан гэсэн хоёр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ялыг нэмж нэгтгэн нийтийн албанд ажиллах эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 40 сая төгрөгөөр торгох ял, 3 жилийн хугацаагаар Орхон аймгийн нутаг дэвсгэрээс гарах зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж, гэмт хэрэг үйлдэж олсон 277 сая төгрөгийг гаргуулж, улсын орлого болгохоор,
>
> -Дээрх хахууль авах гэмт хэрэгт хамтран оролцсон Н.Г-ыг хахууль авах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож нийтийн албанд ажиллах эрхийг 5 жилийн хугацаагаар хасаж, 20 сая төгрөгөөр торгох ял,
>
> -Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Г-ыг бусадтай бүлэглэн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 10 сая төгрөгөөр торгох ял тус тус оногдуулж шийдвэрлэсэн.

Иргэн танд:

Авлигын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж, тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллагын үнэлэмжийг сулруулах зэрэг хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй.

Эх сурвалж: https://prosecutor-capital.greensoft.mn/post/184